



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
ТУШААЛ

2025 оны 06 сарын 13 өдөр

Дугаар 4/46

Улаанбаатар хот

「Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа
эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, хугацаа сунгах,
нэмэлт өөрчлөлт оруулах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.17, 19.18 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 1.1 дэх заалт, Тусгай зөвшөөрлийн комиссын 2025 оны 2 дугаар сарын 4-ний өдрийн 1 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл шинээр олгох, хугацааг сунгах, нэмэлт өөрчлөлт оруулах байгууллагын нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар (Л.Гэрэлмаа)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга Д.Очирбатад даалгасугай.

САЙД



Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын 2025 оны
дугаар сарын 12 өдрийн 9/46
дугаар тушаалын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН ЧИГЛЭЛЭЭР ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ШИНЭЭР ОЛГОХ, ХУГАЦААГ СУНГАХ
БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Байгууллагын нэр	Тусгай зөвшөөрлийн төрөл, чиглэл	Хаяг байршил	Хүчинтэй хугацаа
Нэг. Тусгай зөвшөөрөл шинээр олгох				
1	“Нью грийт кастл” ХХК-ийн “Нью дент про” шүдний эмнэлэг УБД: 9019050086 РД: 5342686	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (клиник) эрхлэх	УБ хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Жуулчны гудамж, Центр 34, 2 давхарт	2028.02.04
2	“Зэмдр” ХХК-ийн “Солонго” эмнэлэг УБД: 9011866604 РД: 7040889	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (клиник) эрхлэх	УБ хот, Баянгол дүүрэг, 2-р хороо, Гранд Плаза Оффис, 14 давхарт 1408 тоот	2028.02.04
Хоёр. Тусгай зөвшөөрлийн хугацааг сунгах				
1	“Мобио” ХХК-ийн эмнэлэг УБД: 9019010112 РД: 2724421	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (клиник) эрхлэх	УБ хот, Хан-Уул дүүрэг 15-р хороо, Нарны зам 10, Шинэ тэрэг плаза, 1 дүгээр давхарт	2028.02.04
Гурав. Нэмэлт өөрчлөлт оруулах				
1	“Естер хаан мед” ХХК-ийн эмнэлэг УБД: 9011823094 РД: 6641016	Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ (клиник) эрхлэх	УБ хот, СХД, 27-р хороо, 21 хороолол 18082, Толгойт гудамж 28/3 тоот	2028.02.04

---000---